

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/8/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Д.Баярсайхан Утас: 261663 Цахим хаяг: bayarsaikhand@audit.gov.mn Аудитын менежер: И.Эрдэнэцэцэг Утас: 261885 Цахим хаяг: erdenetsetsegi@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Лхагвацэнд Утас: 261628 Цахим хаяг: lkhagvatsendb@audit.gov.mn Аудитор: С.Билгүтэй Утас: 261628 Цахим хаяг: bilguteis@audit.gov.mn
--------------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	7
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	7
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	8
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний үйл ажиллагаа	14
3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гадаад, дотоод орчин.....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	15
3.4.1 Мөнгөн хөрөнгө	16
3.4.2 Авлага.....	17
3.4.3 Урьдчилгаа	18
3.4.4 Бараа материал	19
3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө	21
3.4.6 Урт хугацаат хөрөнгө оруулалт	21
3.4.7 Үндсэн хөрөнгө	22
3.4.8 Өр төлбөр.....	24
3.4.9 Засгийн газрын хувь оролцоо	26
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	26
3.5.1 Төсвийн төлөвлөлт	26
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	26
3.5.3 Тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл	27
3.5.4 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт	28
3.5.5 Нэмэлт төсөв.....	28
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	29
4.1 Ерөнхий зүйл.....	29
4.2 Материаллаг байдал	29
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	29
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	29
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	31
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	31
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	31
6 АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	34

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗГНХ	Засгийн нөөц хөрөнгө
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗГХХГ	Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨААТҮГ	Төрийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ҮТП	Үйлдвэрлэл технологийн парк
ҮБС	Үндэсний баялгийн сан
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Б.ЭНХБАЯР ТАНАА

2026.04.27 № 1154
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлсэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийсэн байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн нийт 5,883,169.9 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан, шинж чанарын хувьд материаллаг, дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- “Эрдэнэс Монгол” ХХК нь тайлант хугацаанд охин болон хараат компаниудад олгосон зээлийн санхүүжилтийн гэрээний хугацаа дууссан байхад зээлийн үндсэн төлбөр 15,540.2 сая төгрөг, хуримтлагдсан хүү 1,061.2 сая төгрөг, нийт 16,601.5 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах арга хэмжээг аваагүй;
- “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ-ын Улсын бүртгэлийн гэрчилгээгээр зөвшөөрөгдөөгүй, чиг үүрэгт заагдаагүй бүтцийн 7 нэгж, түүнд харьяалах 791 албан хаагчийг бүтцэд баталж, тайлант онд 16,566.6 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн;
- “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн санхүүгийн тайланд Богдхан төмөр зам төсөлтэй холбоотой 21,132.9 сая төгрөгийн зардал дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэлтэй, төслийн үр ашиг, эдийн засгийн өгөөжийг тодорхойлох боломжгүй, цаашид хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлүүлээгүй;

- Монгол Улсын Их Хурлын 2024 оны 10 дугаар тогтоолоор төрд ногдох ногдол ашгийн орлогоос “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Эрдэнэс Монгол” ХХК болон түүний нэгдэлд хамаарах, төрийн өмчийн оролцоотой бусад аж ахуйн нэгжүүдийн хооронд үүссэн өр, авлагыг суутган тооцохоор зохицуулсан боловч уг зохицуулалт хэрэгжээгүй бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу 2022–2023 оны төрд ногдох ногдол ашгийн 3,305,196.7 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн тайланд бүртгэлтэй;
- “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар Сөрөг санал дүгнэлт авсан, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хуулийн цаглаварт хугацаанд төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй;
- Харьяа 19 байгууллага худалдан авах ажиллагааны хууль, журам мөрдөөгүй нийт 138,102.9 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авсан байна.

Дээр дурдсан зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.34, 25.10, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, 3.1.3, 15 дугаар зүйлийн 15.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 16 дугаар зүйлийн 16.1-ын 1 дэх хэсэг, 20 дугаар зүйл, 20.7, 67 дугаар зүйлийн 67.1, 67.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.6, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 16, Хүлээн зөвшөөрөлт 7, 7(а), (б), Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт 9, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 7 дугаар зүйлийн 7.1 заасантай тус тус нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 22 дугаар "Зарим үндэсний хороо, зөвлөлийг татан буулгах тухай" тогтоолын дагуу Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын Үндэсний хороо, Эрчим хүчний реформыг удирдан зохион байгуулах Үндэсний хороо, Боомтын сэргэлтийн Үндэсний хороо, 20 минутын хот Үндэсний хороо, Алсын хараа 2050 салбар дундын уялдааг хангах Үндэсний хороо, Хяналт, үнэлгээний Үндэсний хороо, Эдийн засгийн хөгжлийн зөвлөлийн ажлын албад татан буугдсантай холбоотой хаалтын балансыг тус тус тайланд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгсөн “Зарим төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн санхүүгийн тайланг төрийн эзэмшлийн хувь оролцоог үндэслэлтэйгээр тодорхойлж, үйл ажиллагааны салбар чиглэлийг харгалзан холбогдох стандарт, хууль тогтоомжид нийцүүлэн зүй зохистой зохион байгуулах” зөвлөмжийг үндэслэн “Эрдэнэс Монгол” ХХК-ийн нэгдлийн харьяа 21, “Эрчист Монгол” ТӨХХК-ийг төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд нэгтгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 44 зорилтын хүрээнд 184 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 90.2 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	10,149,608,658.5	7,775,092,581.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,852,963,382.1	1,108,348,981.0
33	АВЛАГА	1,792,167,615.3	2,118,296,608.7
34	УРЬДЧИЛГАА	4,504,915,306.6	2,360,203,005.8
35	БАРАА МАТЕРИАЛ	1,758,984,131.4	1,971,878,196.5
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	240,578,223.1	216,365,789.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	32,238,565,873.9	35,604,382,662.4
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	5,137,580,359.4	7,144,189,351.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	27,100,985,514.5	28,460,193,310.6
39200	Биет хөрөнгө	7,096,980,595.6	11,676,020,436.2
39300	Биет бус хөрөнгө	13,877,645,197.6	13,835,689,556.2
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	6,126,359,721.3	2,948,483,318.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	42,388,174,532.5	43,379,475,244.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	8,111,777,616.1	7,230,890,091.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,336,014,065.9	5,080,144,100.5
41200	Богино хугацаат зээлийн өглөг	431,943,302.6	157,189,451.3
41300	Өглөг	2,951,287,810.6	2,377,905,149.7
41400	Урьдчилж орсон орлого	1,952,782,952.7	2,545,049,499.5
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,775,763,550.2	2,150,745,991.2
42100	Урт хугацаат үнэт цаас	849,973,000.0	849,973,000.0
42200	Урт хугацаат зээл	1,925,790,550.2	1,300,772,991.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	34,276,396,916.4	36,148,585,152.3
51	Засгийн газрын хувь оролцоо	34,275,732,967.4	36,147,921,203.3
51100	Засгийн газрын оруулсан капитал	39,540,081.7	39,541,081.7
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	2,119,967,784.1	2,119,978,784.1
51103	Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	11,196,548,655.5	11,196,548,655.5
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	757,597.4	757,597.4
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	7,248,489,493.7	7,562,964,732.1
51200	Хуримтлагдсан үр дүн	12,914,870,278.5	13,965,782,535.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	755,559,076.4	1,262,347,816.5
52	Хяналтын бус хувь оролцоо	663,949.0	663,949.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	42,388,174,532.5	43,379,475,244.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	15,214,090,028.7	10,643,545,089.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,075,928,369.5	10,643,047,355.6
121	Хөрөнгийн орлого	11,909.1	6,618.3
122	Тусламжийн орлого	19,687.5	94,005,740.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	138,161,659.2	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,290,957,838.5	5,261,464,848.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,290,803,781.1	5,259,789,135.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,279,217,209.1	5,255,385,510.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,520,876.8	43,465,123.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,111,150.3	69,986,556.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,146,091.4	4,818,246.1
2104	Хангамж, бараа материалын зардал	4,229,121.8	4,654,280.8
2105	Нормативт зардал	45,152.0	48,193.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,722,443.5	2,560,450.4
2107	Томилолт, зочны зардал	7,397,984.2	8,715,296.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,197,607,084.0	5,098,479,466.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,437,305.3	22,657,896.4
212	ТАТААС	412,684.9	245,875.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,173,887.0	4,157,749.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	154,057.5	1,675,712.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	8,923,132,190.2	5,382,080,240.7
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	5,731,244.2	52,546,298.7
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	28,688,577.9	138,745,897.1
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(22,957,333.7)	(86,199,598.4)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	8,900,174,856.5	5,295,880,642.2

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,472,367,209.1	619,757,775.1	8,709,367,166.5	29,801,492,150.7
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	47,328,341.2	(94,907.0)	204,331,905.0	251,565,339.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,519,695,550.3	619,662,868.1	8,913,699,071.5	30,053,057,489.9
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(106,174.0)	54,537,369.4	1,960,202.2	56,391,397.6
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	4,214,813.9	3,712,426.0	-	7,927,239.9
6	Өмчид гарсан өөрчлөлт	82,163,371.3	77,646,412.9	(108,564,069.7)	51,245,714.5
7	Зарласан ногдол ашиг	-	-	(4,792,399,782.0)	(4,792,399,782.0)
8	Тайлант үеийн үр дүн	-	-	8,900,174,856.5	8,900,174,856.5
9	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,605,967,561.5	755,559,076.4	12,914,870,278.5	34,276,396,916.4
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,390,437.6	-	47,066,891.0	49,457,328.7
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,608,357,999.1	755,559,076.4	12,961,937,169.5	34,325,854,245.0
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	508,131,189.6	10,660,443.9	518,791,633.5
13	Өмчид гарсан өөрчлөлт	312,096,800.8	(1,342,449.5)	(55,773,455.8)	254,980,895.5
14	Зарласан ногдол ашиг	-	-	(4,246,922,264.0)	(4,246,922,264.0)
15	Тайлант үеийн үр дүн	-	-	5,295,880,642.2	5,295,880,642.2
16	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	20,920,454,799.9	1,262,347,816.5	13,965,782,535.9	36,148,585,152.3

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	15,486,847,050.9	13,224,218,765.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,348,348,873.8	13,224,218,765.4
120	Нийтлэг татварын бус орлого	15,348,183,951.5	13,130,994,193.5
121	Хөрөнгийн орлого	-	254.7
122	Тусламжийн орлого	164,922.3	93,224,317.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	138,498,177.1	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,695,464,720.2	11,939,311,861.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,695,464,720.2	11,939,311,861.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,682,094,947.0	11,931,676,254.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	926,256,913.8	1,143,308,895.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	248,199,238.5	277,014,174.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	409,877,472.7	540,256,855.2
2104	Хангамж, бараа материалын зардал	3,140,086,336.3	4,586,883,860.6
2105	Нормативт зардал	50,194.7	48,856.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,629,827.5	2,385,492.7
2107	Томилот, зочны зардал	6,432,852.2	7,834,606.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,924,024,827.6	5,367,508,383.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,537,283.6	6,435,130.4
212	ТАТААС	412,684.9	267,026.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,957,088.3	7,368,580.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,791,382,330.7	1,284,906,903.7
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	582,938,006.4	158,503,009.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	2,423,215,754.3	1,615,325,393.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,423,215,754.3	1,615,325,393.5
2200	Дотоод эх үүсвэрээр	2,423,215,754.3	1,615,325,393.5
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,840,277,748.0)	(1,456,822,383.9)
14	Бусад эх үүсвэр	320,896,834.6	241,007,752.5
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	2,351,595,991.1	813,706,673.4
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(2,030,699,156.4)	(572,698,920.9)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(79,594,573.7)	(744,614,401.1)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,932,557,955.9	1,852,963,382.1
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,852,963,382.1	1,108,348,981.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	96,274,609,200.00	82,116,996,034.40	14,157,613,165.60	85.3
12	Татварын бус орлого	96,274,609,200.00	82,116,996,034.40	14,157,613,165.60	85.3
120	Нийтлэг татварын бус орлого	300,000,000.00	338,037,734.00	(38,037,734.00)	112.7
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	-	1,715,635.00	(1,715,635.00)	-
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	300,000,000.00	336,322,099.00	(36,322,099.00)	112.1
122	Тусламжийн орлого	95,974,609,200.00	81,778,958,300.40	14,195,650,899.60	85.2
122005	Төсвөөс санхүүжих	95,974,609,200.00	81,778,958,300.40	14,195,650,899.60	85.2
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	96,274,609,200.00	81,775,111,707.47	14,499,497,492.53	84.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	73,107,609,200.00	60,271,255,412.47	12,836,353,787.53	82.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	70,644,805,400.00	59,156,332,017.02	11,488,473,382.98	83.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	30,305,530,600.00	27,079,627,533.73	3,225,903,066.27	89.4
210101	Үндсэн цалин	17,740,031,700.00	16,349,598,392.54	1,390,433,307.46	92.2
210102	Нэмэгдэл	8,408,279,600.00	6,919,356,667.84	1,488,922,932.16	82.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,463,852,300.00	2,767,654,530.63	(303,802,230.63)	112.3
210104	Урамшуулал	1,693,367,000.00	1,043,017,942.72	650,349,057.28	61.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,728,552,000.00	3,385,794,435.01	342,757,564.99	90.8
210201	Тэтгэврийн даатгал	2,601,699,900.00	2,595,011,658.40	6,688,241.60	99.7
210202	Тэтгэмжийн даатгал	313,876,300.00	417,400,386.60	(103,524,086.60)	133.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	140,976,400.00	59,535,724.58	81,440,675.42	42.2
210204	Ажилгүйдлийн даатгал	140,255,100.00	56,634,131.36	83,620,968.64	40.4
210205	Эрүүл мэндийн даатгал	531,744,300.00	257,212,534.07	274,531,765.93	48.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,863,752,000.00	2,429,477,487.54	434,274,512.46	84.8
210301	Гэрэл, цахилгаан	832,964,900.00	765,799,019.65	67,165,880.35	91.9
210302	Түлш, халаалт	527,039,300.00	390,573,852.41	136,465,447.59	74.1
210303	Цэвэр, бохир ус	191,430,800.00	165,658,603.48	25,772,196.52	86.5
210304	Байрны түрээс	1,312,317,000.00	1,107,446,012.00	204,870,988.00	84.4
2104	Хангамж, бараа материалын зардал	1,797,492,100.00	1,535,113,517.54	262,378,582.46	85.4
210401	Бичиг хэрэг	236,386,700.00	169,895,268.00	66,491,432.00	71.9
210402	Тээвэр, шатахуун	793,999,700.00	766,774,631.84	27,225,068.16	96.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	311,500,100.00	234,719,835.70	76,780,264.30	75.4
210404	Ном, хэвлэл	1,598,600.00	1,598,600.00	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	16,610,400.00	9,568,400.00	7,042,000.00	57.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	437,396,600.00	352,556,782.00	84,839,818.00	80.6
2105	Нормативт зардал	73,904,000.00	48,856,480.00	25,047,520.00	66.1
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,319,900.00	13,521,880.00	3,798,020.00	78.1
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	56,584,100.00	35,334,600.00	21,249,500.00	62.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,078,783,100.00	792,957,410.50	285,825,689.50	73.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	352,979,900.00	234,476,710.00	118,503,190.00	66.4
210602	Тавилга	50,664,800.00	-	50,664,800.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	30,376,300.00	23,590,145.76	6,786,154.24	77.7
210604	Урсгал засвар	644,762,100.00	534,890,554.74	109,871,545.26	83.0
2107	Томиллолт, зочны зардал	7,698,025,900.00	7,315,066,942.60	382,958,957.40	95.0
210701	Гадаад албан томилолт	2,605,485,500.00	2,262,721,693.43	342,763,806.57	86.8
210702	Дотоод албан томилолт	1,678,116,700.00	1,607,863,625.13	70,253,074.87	95.8
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	3,414,423,700.00	3,444,481,624.04	(30,057,924.04)	100.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,	17,077,240,300.00	10,657,657,879.40	6,419,582,420.60	62.4

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	үйлчилгээний төлбөр, хураамж				
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,693,067,600.00	10,394,438,423.30	6,298,629,176.70	62.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,700,100.00	2,700,000.00	100.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	16,823,000.00	16,822,524.00	476.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,040,000.00	-	2,040,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	300,000.00	-	300,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	324,396,500.00	211,502,332.10	112,894,167.90	65.2
210807	Газрын төлбөр	30,381,800.00	24,663,300.00	5,718,500.00	81.2
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,531,300.00	7,531,300.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,021,525,400.00	5,911,780,330.70	109,745,069.30	98.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,003,175,400.00	5,893,480,330.70	109,695,069.30	98.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,350,000.00	18,300,000.00	50,000.00	99.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,462,803,800.00	1,114,923,395.45	1,347,880,404.55	45.3
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	229,757,700.00	229,752,783.50	4,916.50	100.0
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	229,757,700.00	229,752,783.50	4,916.50	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,233,046,100.00	885,170,611.95	1,347,875,488.05	39.6
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	123,587,200.00	86,683,750.00	36,903,450.00	70.1
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,533,423,500.00	510,596,696.25	1,022,826,803.75	33.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	576,035,400.00	287,890,165.70	288,145,234.30	50.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	23,167,000,000.00	21,503,856,295.00	1,663,143,705.00	92.8
220001	Барилга байгууламж	19,830,600,000.00	18,197,022,038.00	1,633,577,962.00	91.8
221001	Их засвар	1,705,200,000.00	1,675,712,857.00	29,487,143.00	98.3
222001	Тоног төхөөрөмж	1,631,200,000.00	1,631,121,400.00	78,600.00	100.0
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	341,884,326.93	(341,884,326.93)	-
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(341,884,326.93)	341,884,326.93	-
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(341,884,326.93)	341,884,326.93	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	65,608,018.01	(65,608,018.01)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	202,271,322.98	(202,271,322.98)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,117	415	702	37.2
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	7	4	3	57.1
610001	Төсвийн байгууллага	7	4	3	57.1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	537	310	227	57.7
620001	Удирдах ажилтан	27	6	21	22.2
620002	Гүйцэтгэх ажилтан	338	132	206	39.1
620003	Үйлчлэх ажилтан	172	172	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	537	99	438	18.4
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	210	36	174	17.1
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	221	-	221	-
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	17	3	14	17.6
650013	Шатлалгүй цалин	83	60	23	72.3
650014	Төрийн үйлчилгээний мэргэжлийн (ТҮМ)	6	-	6	-
66	НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	36	2	34	5.6
660001	ТАХУУЛИАР ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	36	2	34	5.6

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	13,920,029,934.07
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,920,029,934.07
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,913,182,654.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,913,182,654.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,913,182,654.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,703,065,172.01
210101	Үндсэн цалин	704,432,822.17
210102	Нэмэгдэл	946,275,769.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,356,580.04
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129,195,158.43
210201	Тэтгэврийн даатгал	129,195,158.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	120,587,398.00
210301	Гэрэл, цахилгаан	527,558.00
210304	Байрны түрээс	120,059,840.00
2104	Хангамж, бараа материалын зардал	887,089,823.48
210401	Бичиг хэрэг	2,865,466.00
210402	Тээвэр, шатахуун	16,750,405.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,902,852.58
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	860,571,099.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	238,292,790.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,088,700.00
210604	Урсгал засвар	213,204,090.00
2107	Томилолт, зочны зардал	375,093,483.00
210701	Гадаад албан томилолт	24,290,820.00
210702	Дотоод албан томилолт	136,767,840.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	214,034,823.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,566,416,392.17
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,561,037,392.17
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,379,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,893,442,437.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,893,442,437.19
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	6,847,279.79
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(6,847,279.79)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(6,847,279.79)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний үйл ажиллагаа

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь мэргэжлийн, өндөр түвшний, цаг үеэ олсон зөвлөгөө, дэмжлэгээр Ерөнхий сайд, танхимыг шуурхай хангах, Засгийн газрын тасралтгүй, хэвийн, үр ашигтай ажиллагааны зохистой орчныг бүрдүүлэхэд оршино гэж эрхэм зорилгоо тодорхойлсон бөгөөд стратегийн 13 зорилтыг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгсөн “Зарим төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн санхүүгийн тайланг төрийн эзэмшлийн хувь оролцоог үндэслэлтэйгээр тодорхойлж, үйл ажиллагааны салбар чиглэлийг харгалзан холбогдох стандарт, хууль тогтоомжид нийцүүлэн зүй зохистой зохион байгуулах” зөвлөмжийг үндэслэн дараах байгууллагуудын санхүүгийн тайланг нэмж нэгтгэн тайлагнасан байна. Үүнд: “Эрдэнэс монгол” ХХК, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ, “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК, “Эрдэнэс Алт ресурс” ХХК, “Эрдэнэс оюу толгой” ХК, “Монголын газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК, Тавантолгой төмөр зам ХХК, Эрдэнэт медиал эмнэлэг, Монголиан Смелтинг Корпорейшн ХХК, “Мон-Атом” ХХК, “Чингис хаан ҮБС” ХХК, “Эрдэнэс ашид” ХХК, “Эрдэнэс метан” ХХК, “Эрдэнэс ҮТП” ХХК, “Зэс боловсруулах цогцолбор” ХХК, “Монголын эрдэс баялгийн бирж” ХХК, “Эрдэнэс Ассет менежмент” ХХК, Эрдэнэс газ төслийн нэгж, “Эрчист Монгол” ХХК.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 22 дугаар “Зарим үндэсний хороо, зөвлөлийг татан буулгах тухай” тогтоолын дагуу Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын Үндэсний хороо, Эрчим хүчний реформыг удирдан зохион байгуулах Үндэсний хороо, Боомтын сэргэлтийн Үндэсний хороо, 20 минутын хот Үндэсний хороо, Алсын хараа 2050 салбар дундын уялдааг хангах Үндэсний хороо, Хяналт, үнэлгээний Үндэсний хороо, Эдийн засгийн хөгжлийн зөвлөлийн ажлын албад татан буугдсантай холбоотой хаалтын балансыг тайланд нэгтгэсэн байна.

3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гадаад, дотоод орчин

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, Ерөнхий сайд, Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний бодлогыг төлөвлөх, боловсруулах, дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, яам, агентлагийн болон аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааг шуурхай зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөгөө, дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ. Үүнд:

- Засгийн газрын дотоод, гадаад бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлээр Засгийн газрын танхимд зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тэргүүлэх чиглэл, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх, бодлого, шийдвэрийг боловсруулан гаргахад Ерөнхий сайд, танхимын үйл ажиллагаанд зөвлөгөө, дэмжлэг үзүүлэн Засгийн газрын хуралдаанаас гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;
- Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын шийдвэрийн биелэлт, Засгийн газрын дотоод мэдээлэл, Засгийн газраас Ерөнхийлөгч, Улсын Их Хуралтай харилцах асуудал, төрийн албаны хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх, төрийн албаны хүний нөөцийн бодлого, чиглэл боловсруулах, төрийн албан хаагчийг сургах, мэргэшүүлэх, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг, туслалцаа үзүүлэх;
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг чиглүүлж, удирдамжаар хангах, зохицуулах;
- Төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг Засгийн газрын бодлого, нийтлэг зорилтод чиглүүлэн зохицуулах, орон нутгийн хөгжлийн нэгдсэн бодлого, орон нутгийн засаг захиргааны зохион байгуулалт, Засаг даргын үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар хангах, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд

мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа байдалд хяналт шалгалт хийж, тэдгээрийн үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангах;

- Засгийн газрын үйл ажиллагааг цахим хэлбэрээр хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх замаар төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдааг сайжруулах, мэдээллийн урсгалыг түргэтгэх, Засгийн газар-хувийн хэвшил, Засгийн газар-иргэний нийгмийн түншлэлийг хөгжүүлэх;
- Хэрэг эрхлэх газар, түүний харьяа байгууллагуудын нийтлэг үйлчилгээний бодлогыг боловсруулж батлуулах, үйл ажиллагаанд нь зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, удирдлага, зохицуулалтаар хангах.

Тайлант онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Зөвшөөрлийн тухай хууль;
- Монгол Улсын Засгийн газрын “Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлан тухай” 2025 оны 21 дүгээр тогтоол;
- Монгол Улсын Засгийн газрын “Зарим үндэсний хороо, зөвлөлийг татан буулгах тухай” 2025 оны 22 дугаар тогтоол;
- Монгол Улсын Засгийн газрын “Журам батлах тухай” 2025 оны 43 дугаар тогтоол.

ТЕЗ-ийн хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгийг ирүүлэхээр заасан. ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн тайланд хамаарах тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн болон нэмэлт төсвийн гүйцэтгэл, тэдгээрийн танилцуулгуудыг хавсаргаж ирүүлсэн байна.

ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тус ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 991,300.7 сая төгрөгөөр буюу 2.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,852,963.4	1,108,349.0	(744,614.4)
Авлага	1,792,167.6	2,118,296.6	326,129.0
Урьдчилгаа	4,504,915.3	2,360,203.0	(2,144,712.3)
Бараа материал	1,758,984.1	1,971,878.2	212,894.1
Бусад эргэлтийн хөрөнгө	240,578.2	216,365.8	(24,212.4)
Урт хугацаат хөрөнгө оруулалт	5,137,580.4	7,144,189.4	2,006,609.0
Үндсэн хөрөнгө	27,100,985.5	28,460,193.3	1,359,207.8
Нийт хөрөнгө	42,388,174.5	43,379,475.2	991,300.7
Өр төлбөр	8,111,777.6	7,230,890.1	(880,887.5)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	34,276,396.9	36,148,585.1	1,872,188.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	42,388,174.5	43,379,475.2	991,300.7

Эх сурвалж: ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материал, урт хугацаат хөрөнгө оруулалт, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансдууд нөлөө бүхий өөрчлөлт орсон байна. Нийт хөрөнгийн 17.9 хувийг эргэлтийн хөрөнгө, 82.1 хувийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,108,349.0 сая төгрөг болж, өмнөх оноос 744,614.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассанд байгаа бэлэн мөнгө	209.7	273.9	64.2
Төгрөг	147.2	115.9	(31.2)
Гадаад валют	62.6	158.0	95.5
Банкинд байгаа бэлэн мөнгө	1,826,225.6	1,083,793.9	(742,431.7)
Төгрөг	1,760,036.7	840,827.6	(919,209.2)
Төрийн сангийн харилцах	28,826.2	20,342.0	(8,484.1)
Арилжааны банк дахь харилцах	1,731,210.6	820,485.5	(910,725.0)
Гадаад валют	66,188.9	242,966.3	176,777.5
Банкинд байгаа хадгаламж	66,188.9	242,966.3	176,777.5
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	5.2	5.2
Хадгаламж	26,528.1	24,276.0	(2,252.1)
ДҮН	1,852,963.4	1,108,349.0	(744,614.4)

Эх сурвалж: ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд төсвийн байгууллага, ТӨҮГ-ын үлдэгдэл 34,384.3 сая төгрөг буюу 3.1 хувь, “Эрдэнэс монгол” ХХК-ийн нэгдлийн харьяа байгууллагууд 1,073,964.7 сая төгрөг буюу 96.9 хувийг эзэлж байна.

Мөнгөн хөрөнгийн бууралтад дараах ажил, гүйлгээнүүд голлон нөлөөлсөн байна. Тухайлбал:

- “Эрдэнэс Тавантолгой” ХК нь Засгийн газрын 2022 оны 94 дүгээр тогтоолын дагуу хэрэгжиж буй газрын тос дамжуулах хоолойн төсөлд 266.5 сая ам.долларын буюу ойролцоогоор 919,405.9 сая төгрөгийн санхүүжилтийг нүүрсний нийлүүлэлтээр төвлөрүүлсэн, Гашуунсухайт–Ганцмод чиглэлийн хил дамнансан төмөр замын

төсөлд 254,657.9 сая төгрөг, нүүрс тээврийн конвейрийн системийн төсөлд 244,014.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан зэргээс мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 889,350.7 сая төгрөгөөр буурсан;

- “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 30,630.9 сая төгрөгөөр буурсан нь Монгол Улсын Засгийн Газрын 2025 оны 103 дугаар тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг “Монголын төмөр зам” ТӨХК-д түрээсийн гэрээгээр шилжүүлснээс өөрийн орлого буурсантай холбоотой;
- Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 2,386.0 сая төгрөгөөр буурсан нь 5 аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн гэрээт ажлын төлбөрийн үлдэгдэл 2,300.8 сая төгрөгийг барагдуулсан нь нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой 65,170.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Анхан шатны бүрдэл дутуу баримтаар 266.5 сая төгрөгийн ажил, гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн, /Ерөнхий сайдын ажлын алба 11.0 сая төгрөг, Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа 36.2 сая төгрөг, Мон-Атом ХХК 0.6 сая төгрөг, Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК 115.0 сая төгрөг, Эрдэнэт медиал эмнэлэг 0.2 сая төгрөг/;
- Цалин, хөлс, тэтгэмж, урамшууллыг 23,860.4 сая төгрөгөөр илүү тооцож олгосон, /Төр засгийн үйлчилгээг эрхлэх газар 147.6 сая төгрөг, Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар 39.5 сая төгрөг, Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ 24.7 сая төгрөг, Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа 118.9 сая төгрөг, Багануур ХК 29.2 сая төгрөг, Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК 0.5 сая төгрөг, Мон-Атом ХХК 1.1 сая төгрөг, Тавантолгой төмөр зам ХХК 220.2 сая төгрөг, Эрдэнэс Монгол ХХК 1,604.9 сая төгрөг, Эрдэнэс ашид ХХК 7.6 сая төгрөг, Эрдэнэс Оюутолгой ХХК 104.6 сая төгрөг, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ 19,240.4 сая төгрөг, Эрдэнэс критикал минералс ТӨҮГ 2,029.3 сая төгрөг, Эрдэнэс алт ресурс ХХК 59.3 сая төгрөг, Эрдэнэт медиал эмнэлэг 182.3 сая төгрөг, Эрчист Монгол ТӨХХК 49.3 сая төгрөг/;
- Арвилан хэмнэлтгүй, зориулалт бусаар 40,230.7 сая төгрөг зарцуулсан, /Засгийн газрын хэрэг эрхлэх газар 88.0 сая төгрөг, Монгол Улсын Шадар сайдын ажлын алба (Бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал хариуцсан) 21.9 сая төгрөг, Монгол Улсын Шадар сайдын ажлын алба (Худалдаа, гадаад хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан) нь 14.1 сая төгрөг, Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа 18.9 сая төгрөг, Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ 6.8 сая төгрөг, Багануур ХК 22.4 сая төгрөг, Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК 14.2 сая төгрөг, Шивээ-Овоо ХК 1.1 сая төгрөг, Эрдэнэс Монгол ХХК 2,551.9 сая төгрөг, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ 37,325.8 сая төгрөг, Эрдэнэс критикал минералс ТӨҮГ 41.5 сая төгрөг, Эрдэнэт медиал эмнэлэг 30.1 сая төгрөг/;
- Эрх бүхий албан тушаалтны тушаал, шийдвэргүй гадаад албан томилолтын зардал гаргасан, албан томилолтын зардлын нормыг хэтрүүлэн зарцуулсан зэрэг 813.2 сая төгрөгийн зардал гаргасан, /Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа 34.0 сая төгрөг, Эдийн засгийн хөгжлийн төв УТҮГ 51.8 сая төгрөг, Эрдэнэс Монгол ХХК 83.7 сая төгрөг, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ 641.2 сая төгрөг/.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 2,118,296.6 сая төгрөг болж, өмнөх оноос 326,129.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	74.3	41.3	(32.9)
Төлбөртэй үйлчилгээний авлага	123.9	1,185.4	1,061.6
Татаас, санхүүжилтийн авлага	-	260.6	260.6
Дансны авлага /ТӨҮГ/	825,235.6	927,739.2	102,503.6
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	220,480.1	295,232.7	74,752.6
Бусад авлага	746,253.9	893,837.4	147,583.5
Дүн	1,792,167.6	2,118,296.6	326,129.0

Эх сурвалж: ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 86.1 хувийг байгууллагаас авах авлага, 13.9 хувийг татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага тус тус эзэлж байна.

Авлагын дансны үлдэгдэлд дараах байгууллагуудад материаллаг хэмжээний өөрчлөлт

орсон байна. Тухайлбал:

- “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн авлагын үлдэгдэл 1,030,611.5 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 52,461.8 сая төгрөгөөр буюу 5.4 хувиар өссөн байна. Авлагын үлдэгдэл нэмэгдсэн нь үндсэндээ төлбөр тооцооны хугацааны зөрүүтэй холбоотой бөгөөд 12 дугаар сард хийгдсэн нүүрсний борлуулалтын төлбөрүүд тайлант хугацааны эцэст Монголын хөрөнгийн биржийн шилжилтийн дансанд үлдсэнтэй холбоотой байна;
- “Таван толгой төмөр зам” ХХК-ийн авлагын үлдэгдэл 77,974.1 сая төгрөгөөр өссөн нь Багахангай-Хөшигийн хөндий чиглэлийн салбар төмөр зам барих төслийн санхүүжилтийг арилжааны банканд байрших хадгаламжийг барьцаалсан 78,000.0 сая төгрөгийн зээл авч “Монголын төмөр зам” ТӨХК-иас авах авлагаар тайлагнасан нь нөлөөлсөн;
- “Эрдэнэс монгол” ХХК-ийн Авлагын дансны үлдэгдэл 6,605,929.9 сая төгрөг болж, өмнөх оноос 3,224,766.4 сая төгрөгөөр буюу 95.4 хувиар өссөн нь борлуулалтын авлага, холбоотой талаас авах авлага нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн;
- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын авлага дансны үлдэгдэл 210,425.4 сая төгрөг болж, 191,579.9 сая төгрөгөөр өссөн нь татвар, НДШ-ийн авлага 177,792.5 сая төгрөг болж 175,525.5 сая төгрөгөөр өссөн нь төсөвт төлөх татварыг бүрэн төвлөрүүлэх, 2026 оны татварын ногдлыг урьдчилж төлөх чиглэлийг холбогдох төрийн байгууллагуудаас ирүүлсний дагуу татварыг урьдчилж төлснөөс шалтгаалсан;
- Авлага дансны үлдэгдэл НӨАТ-ын авлага 374.4 сая төгрөг, бэлтгэн нийлүүлэгчтэй холбоотой барьцааны авлага 120.1 сая төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалж 568.4 сая төгрөгөөр өссөн.

Аудитын илрүүлэлт:

Авлагын данстай холбоотой 214,930.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- *Үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, авлагыг үнэн зөв бүртгээгүй /Төр засгийн үйлчилгээг эрхлэх газар 60.3 сая төгрөг, Удирдлагын академи 2.6 сая төгрөг, Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ 76.3 сая төгрөг, Багануур ХК 1,255.4 сая төгрөг, Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК 129.1 сая төгрөг, Тавантолгой төмөр зам ХХК 83,996.8 сая төгрөг, Эрчист Монгол ТӨХХК 1,112.5 сая төгрөг, Эрдэнэс Монгол ХХК 22,728.1 сая төгрөг, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ 42,862.8 сая төгрөг, Эрдэнэс метан ХХК 3.4 сая төгрөг, Эрдэнэс ҮТП ХХК 950.3 сая төгрөг, Эрдэнэс алт ресурс ХХК 42,326.6 сая төгрөг, Эрдэнэт медиал эмнэлэг 76.6 сая төгрөг, Зэс боловсруулах цогцолбор ХХК 2.3 сая төгрөг/;*
- *Хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй /Монголын газрын тос боловсруулах үйлдвэр ХХК 2,746.3 сая төгрөг, Эрдэнэс Монгол ХХК 16,601.5 сая төгрөг/*

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 2,360,203.0 сая төгрөг болж, өмнөх оноос 2,144,712.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төсөвт байгууллага	8.5	1,490.1	1,481.6
Хувийн хэвшлийн үйлдвэр, аж ахуйн газар	-	28.4	28.4
Урьдчилж гарсан зардал	4,497,841.5	2,355,632.4	(2,142,209.1)
Урьдчилгаа тооцоо	7,065.4	3,052.1	(4,013.3)
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	5,312.0	3,052.1	(2,259.9)
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	64.2	-	(64.2)
Томилолтын урьдчилгаа	1,689.2	-	(1,689.2)
Дүн	4,504,915.3	2,360,203.0	(2,144,712.3)

Эх сурвалж: ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдлийн 99.8 хувийг урьдчилж гарсан зардал, 0.2 хувийг урьдчилгаа тооцоо тус тус эзэлж байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэлд дараах байгууллагуудад материаллаг хэмжээний өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн дансны нийт үлдэгдэл 2,046,126.7 сая төгрөг байна. Энэ нь өмнөх оны 2,821,204.1 сая төгрөгтэй харьцуулахад 775,077.4 сая төгрөгөөр буюу 27.5 хувиар буурсан үзүүлэлт юм. Урьдчилж гарсан зардлын үлдэгдэл буурсан нь ногдол ашгийн урьдчилгаа төлбөр 560,916.2 сая төгрөгийг тооцоо хаасантай холбоотой;
- “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн дансны үлдэгдэл 176,170.8 сая төгрөг болж, өмнөх оноос 1,338,864.4 сая төгрөгөөр буурсан нь урьдчилгаа дансанд хуримтлуулан бүртгэсэн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн 1,340,864.2 сая төгрөг, Тавантолгой нүүрс ачилт логистикийн төв төслийн 16,123.8 сая төгрөгийг үндсэн хөрөнгийн данс руу хааж бүртгэсэн нь нөлөөлсөн;
- “Монголын газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн урьдчилж төлсөн зардлын үлдэгдэл 19,856.0 сая төгрөгөөр буурсан нь Norinco International Cooperation Ltd-д олгосон дамжуулах хоолойн барилгын ажлын урьдчилгаа төлбөрийг гүйцэтгэлээр хааж, холбогдох ажлыг хүлээн авсантай холбоотой;
- “Эрдэнэс оюу толгой” ХХК-ийн урьдчилж төлсөн зардлын үлдэгдэл 5,774.1 сая төгрөгөөр буурсан нь “Би эм Си Эм” ХХК-тай 2024 онд байгуулсан “Барилга байгууламж худалдан авах” 20240102005 дугаар гэрээний дагуу олгосон урьдчилгаа төлбөрийг гүйцэтгэлээр хааж, холбогдох хөрөнгийг бүртгэлд тусгасантай холбоотой;
- “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын урьдчилж төлсөн зардал данс 6,866.5 сая төгрөг болж 7,795.4 сая төгрөгөөр буурсан байна. Бүтээгдэхүүн тээвэрлэх зориулалттай ачааны вагон түрээслэх үйлчилгээний төлбөрийг урьдчилж төлдөг бөгөөд тус үйлчилгээг авснаар 9,979.6 сая төгрөгөөр урьдчилж төлсөн зардал буурсан нь нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

Урьдчилгаа данстай холбоотой 1,975,379.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Багануур ХК нь тайлант онд 14,874.9 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг олгохдоо цалингийн урьдчилгаа дансанд бичилт хийхгүйгээр цалингийн өглөг дансны дт-т бүртгэж, тайлагнасан;
- Мон-Атом ХХК "Уран-2" нэртэй богино хэмжээний киног орлогод бүрэн хүлээж аваагүй, 2 байгууллагад тус бүр 20.0 сая төгрөгийн гэрээг дүгнэсэн акт үйлдэн "Урьдчилж төлсөн зардал" дансны оны эхний үлдэгдлийг зар сурталчилгааны зардалд бүртгэсэн;
- Эрдэнэс тавантолгой ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан "Хувьцаа эзэмшигчдийн гэрээ"-нд заасны дагуу төслийн санхүүжилтийг "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн "Тавантолгой төмөр зам" ХХК-д оруулсан хөрөнгө оруулалтад тооцож, хувьцаанд хөрвүүлэхээр зохицуулсан байна. Гэвч "Эрдэнэс Тавантолгой" ХК-аас төслийн санхүүжилтэд олгосон нийт 3,283,903.7 сая төгрөгөөс 1,346,716.6 сая төгрөгийг хувьцаанд хөрвүүлсэн бөгөөд үлдсэн 1,937,187.0 сая төгрөгийг гэрээний дээрх заалтын дагуу хувьцаанд бүрэн хөрвүүлээгүй, "урьдчилгаа" дансанд үлдэгдлээр бүртгэж байгаа нь гэрээний заалт зөрчигдсэн;
- Эрдэнэс Монгол ХХК нь "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд "Шинэ Хархорум" хотын төлөвлөлтөд тусгагдсан ногоон байгууламж, ойн зурвас байгуулах зорилтыг хангаж орон зайн оновчтой төлөвлөлтөөр экосистем, эдийн засгийн үр ашигтайгаар мод тарьж арчилж ургуулах зорилгын хүрээнд тайлант онд 2,134.5 сая төгрөгийн 21.0 мянган ширхэг навчит, 9.0 мянган ширхэг шилмүүст мод тарьсныг урьдчилж төлсөн тооцоо дансанд бүртгэсэн нь стандартын дагуу хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж буй эсэхийг үнэлэх, мөн төрийн өмч хөрөнгөд тавих хяналт алдагдах эрсдэлтэй;
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь 2004-2021 оны хооронд 98 бэлтгэн нийлүүлэгчийн гэрээт ажлын урьдчилгаанд төлсөн 21,142.7 сая төгрөгийн ажлын гэрээний хэрэгжилтэд тавих хяналт сул байгаагаас 94 бэлтгэн нийлүүлэгчийн 20,259.0 сая төгрөгийн найдваргүй авлагын хасагдуулаг үүссэн бөгөөд авлагыг барагдуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй байна.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 1,971,878.2 сая төгрөг болж, өмнөх оноос 212,894.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)

Түүхий эд материал	578,312.5	617,355.1	39,042.6
Тусгай зориулалттай материал	578,282.4	617,288.7	39,006.2
Эм боох материал	30.1	66.5	36.4
Дуусаагүй үйлдвэрлэл	19,030.1	23,447.4	4,417.3
Бэлэн бүтээгдэхүүн	889,680.9	1,021,722.6	132,041.7
Хангамжийн материал	271,960.6	309,353.1	37,392.5
Бичиг хэргийн материал	402.2	825.3	423.1
Аж ахуйн материал	3,059.5	2,292.4	(767.2)
Сэлбэг хэрэгсэл	110,356.3	156,674.7	46,318.4
Түлш, шатах тослох материал	8,363.4	9,842.0	1,478.6
Барилгын засварын материал	638.4	682.9	44.5
Хүнсний материал	553.8	629.3	75.5
Бусад хангамжийн материал	148,587.0	138,406.5	(10,180.5)
Дүн	1,758,984.1	1,971,878.2	212,894.1

Эх сурвалж: ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны үлдэгдлийн 15.7 хувийг хангамжийн материал, 51.8 хувийг бэлэн бүтээгдэхүүн, 31.3 хувийг түүхий эд материал эзэлж байна.

Бараа материал дансны үлдэгдэлд дараах байгууллагуудад материаллаг хэмжээний өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн бараа материалын нийт үлдэгдэл 675,165.5 сая төгрөг байна. Энэ нь өмнөх оны 506,601.1 сая төгрөгтэй харьцуулахад 168,564.4 сая төгрөгөөр буюу 33.3 хувиар өссөн үзүүлэлт юм. Бараа материалын өсөлт нь үндсэндээ нүүрсний олборлолтын хэмжээ нэмэгдсэнтэй холбоотойгоор бэлэн бүтээгдэхүүн буюу нүүрс, тос, тослох материал, сэлбэг хэрэгслийн нөөц нэмэгдсэнтэй холбоотой. Түүнчлэн компанийн өөрийн өмчлөлийн уулын ажлын техникүүд нэмэгдсэн нь сэлбэг хэрэгслийн нөөц бүрдүүлэлтэд нөлөөлсөн байна;
- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын бараа материал дансны үлдэгдэл 648,411.0 сая төгрөг болж, 43,051.5 сая төгрөгөөр өссөн нь үйлдвэрлэлийн тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангах үндсэн технологийн материал 42,000.7 сая төгрөгөөр, сэлбэг хэрэгсэл 11,503.9 сая төгрөгөөр, олборлож боловсруулсан зэсийн баяжмал оны эхнээс 31,800.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн;
- “Шивээ-Овоо” ХК-ийн бараа материалын үлдэгдэл 27,232.3 сая төгрөгт хүрч өмнөх оноос 3,429.5 сая төгрөгөөр өссөн нь оны эцэст дизелийн түлш болон тэсрэх материалын нөөцийг бүрдүүлсэн;
- “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн бараа материалын үлдэгдэл 24,562.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Төмөртэй уурхайн олборлосон хүдэр 8,152.4 сая төгрөгөөр, Төмөртолгой уурхайн олборлосон хүдэр 2,881.5 сая төгрөгөөр өссөн, мөн үйлдвэрлэл болон борлуулалтын хэмжээ нэмэгдсэний улмаас түргэн элэгдэх сэлбэг материалын нөөц бүрдүүлсэнтэй холбоотой сэлбэг хэрэгсэл, шатах тослох материал 12,306.5 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Бараа материалын данстай холбоотой 18,771.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Шивээ-Овоо ХК нь бараа материалын дансанд бүртгэлтэй, техникийн шинэчлэлтэй холбоотойгоор компанид ашиглагдахгүй болсон 193 нэрийн 463.8 сая төгрөгийн сэлбэгийг эргэлтэд оруулах талаар өгсөн өмнөх оны албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлын өртгийн тооцоонд их засварын зардал болон өмнөх онд төлсөн газрын төлбөр гэх мэт 479.3 сая төгрөгийн зардлыг оруулан тайлагнасан, Хөрөнгийн удирдлагын зохистой менежмент хэрэгжүүлж ажиллаагүй, техник тоног төхөөрөмжийн хоцрогдол, насжилт зэргээс шалтгаалсан гэх 2003 оноос хойш хуримтлагдсан ашиглалтгүй 1,846 нэр төрлийн, нийт 4,163.7 сая төгрөгийн өртөг бүхий сэлбэг хэрэгслийн үлдэгдэл байна;
- Монголын газрын тос боловсруулах үйлдвэр ХХК нь 2025 оны зорилтот түвшин, хөрөнгө оруулалт, худалдан авалтын төлөвлөгөөнд тодотгол хийж хэрэгжилтийг ханган ажилласан боловч үйл ажиллагааны батлагдсан зардал гүйцэтгэлээрх зардлын ангилал, зарцуулалт зөрүүтэй мөн бичиг хэрэг, шатах тослох материалыг худалдан авах төлөвлөгөөнд тусгалгүй 76.4 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн;
- Эрчист Монгол ТӨХХК нь шаардах хуудаст нэг, хоёрдугаар гарын үсэг зураагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу 15.7 сая төгрөгийг зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан;

- Тавантолгой төмөр зам ХХК-ийн завсрын аудитаар бараа материалын дансны үлдэгдэлд түүвэр тулгалт хийж, биет тест хэрэгжүүлэхэд төмөр замын өртөө, байгууламжийн бүсэд хашаа барьж байгуулах зорилгоор худалдан авсан нийт 168.4 сая төгрөгийн төмөр шон, савх төмөр, дай төмөр гэх мэт хашаа барьж байгуулах материалыг зориулалтын дагуу ашиглаагүй, гадаа талбайд ил задгай байршуулсан, дахин ашиглах боломжгүй болох, үрэгдэх эрсдэлтэй мөн тээвэр, суурь бүтцийн үйл ажиллагаатай хамааралтай 1,979.5 сая төгрөгийн бараа материал байгаагаас 149.6 сая төгрөгийн дугуй, резинэн жийрэг зэрэг материалууд нь хадгалалтын хугацаа дуусах, дахин ашиглах боломжгүй болох эрсдэлтэй байна;
- Эрдэнэс тавантолгой ХК нь уурхайн үйлдвэрлэлийн тасралтгүй, хэвийн ажиллагааг хангахад шаардлагатай стратегийн ач холбогдол бүхий бараа материал, сэлбэг хэрэгслийн нөөцийг эрсдэлийн удирдлагад суурилан зохистой түвшинд төлөвлөж, бүрдүүлээгүй нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд доголдол үүсэх, зогсолт бий болох эрсдэлийг нэмэгдүүлсэн;
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь нэг жил хүртэлх жилийн насжилттай 308.1 сая төгрөг, нэгээс гурав хүртэлх жилийн насжилттай 3,337.5 сая төгрөг, гурваас дээш жилийн насжилттай 6,146.1 сая төгрөг, нийт 34 нэр төрлийн 9,791.7 сая төгрөгийн бараа материалыг удаан хугацаанд нөөцөлсөн нь цаашид ашиглалтын шаардлага хангах, ашиглах эсэх нь тодорхойгүй, 127.3 сая төгрөгийн үнийн дүнтэй 21 нэр төрлийн хөрөнгийн шинж чанартай хөрөнгүүдийг дансны ангилал зөрүүлэн бүртгэсэн;
- Эрдэнэс критикал минералс ТӨҮГ нь 9 дансны 101,386.5 сая төгрөгийн бараа материалын үлдэгдлийг тооллогын тайлан, дэлгэрэнгүй тайлантай тулган шалгахад 2,882.5 сая төгрөгийн бараа материал сүүлийн 3 жил хөдөлгөөн ороогүй байна;
- Эрдэнэт медикал эмнэлэг тайлант онд 19.9 сая төгрөгөөр худалдан авсан Детекторын тэжээлийн блокийг бараа материалын дансаар дамжуулан зарлагдсан;
- Чингисхаан ҮБС ХХК нь тээврийн хэрэгслийн шатахууны тооцоог Зам, тээврийн хөгжлийн сайдын баталсан норм, нормативын дагуу бодож, шатахууны үлдэгдлийг баталгаажуулаагүйгээс 1.7 сая төгрөгийн шатахуун илүү олгосон, шатахууны худалдан авалт бүрд олгодог хөнгөлөлтийн урамшуулал болох 0.2 сая төгрөгийн санхүүгийн тайланд тусгаагүй.

3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 216,365.8 сая төгрөг болж, өмнөх оноос 24,212.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	122,083.3	141,860.3	19,777.0
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	108,836.4	69,056.2	(39,780.2)
БЗЭБуй эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	9,658.5	5,449.3	(4,209.2)
Дүн	240,578.2	216,365.8	(24,212.4)

Эх сурвалж: ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэлд дараах байгууллагуудад материаллаг хэмжээний өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө данс 4,657.8 сая төгрөг болж 5,000.8 сая төгрөгөөр буурсан нь ажилчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор орон сууцны хуучин барилгыг дахин төлөвлөж, “Батс-Өргөө” ХХК-аар 165 айлын 2 орон сууцыг гүйцэтгүүлж, төлбөрөө бүрэн төлсөн орон сууцны өртгийг данснаас хассантай холбоотой байна. Тус дансны үлдэгдэл нь гэрээний хуваарийн дагуу төлбөрийн үлдэгдэлтэй 42 ажилтны орон сууцны өртөг байна.
- “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн бусад эргэлтийн бус хөрөнгийн нийт дүн 3,554,366.6 сая төгрөг болж 198,580.2 сая төгрөгөөр буюу 5.3 хувиар буурсан нь хөрс хуулалтын хөрөнгийн элэгдэл, урт хугацаат авлагын богино хугацаат хэсэг рүү шилжүүлсэн, мөн урт хугацаат нөхөн сэргээлтийн хөрөнгийн үнэлгээний өөрчлөлттэй холбоотой.

3.4.6 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны эцсийн үлдэгдэл 7,144,189.4 сая төгрөг болж, өмнөх оноос 2,006,609.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Урт хугацаат хөрөнгө оруулалт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урт хугацаат зээл	5,137,580.4	7,144,189.4	2,006,609.0
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	936,822.7	2,295,169.2	1,358,346.5
Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл	936,822.7	2,295,169.2	1,358,346.5
Урт хугацаат хөрөнгө оруулалт	4,200,757.6	4,849,020.1	648,262.5
Дүн	5,137,580.4	7,144,189.4	2,006,609.0

Эх сурвалж: ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэлд дараах байгууллагуудад материаллаг хэмжээний өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн урт хугацаат хөрөнгө оруулалтын нийт дүн 2,040,526.9 сая төгрөг өмнөх оноос 693,763.2 сая төгрөгөөр буюу 51.5 хувиар өссөн нь “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн эзэмшлийн хувь 66 хувиас 100 хувь болж нэмэгдсэнтэй холбоотой байна;
- “Эрдэнэс Монгол” ХХК-ийн урт хугацаат хөрөнгө оруулалтын дансны үлдэгдэл 9,168,440.8 сая төгрөг болж, өмнөх оноос 11.0 сая төгрөгөөр нэмэгдсэн Монгол улсын Засгийн газрын тогтоолоор “Зэс боловсруулах цогцолбор” ХХК-ийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин компани хэлбэрээр байгуулж, 10.0 сая төгрөгийн “Чингис хаан Үндэсний баялгийн сан” ХХК-ийг байгуулж 1.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.

3.4.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 28,460,193.3 сая төгрөг болж, өмнөх оноос 1,359,207.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	7,096,980.6	11,676,020.4	4,579,039.8
Барилга, байгууламж, орон сууц	1,593,328.8	4,471,494.4	2,878,165.6
Авто-тээврийн хэрэгсэл	1,102,740.1	1,769,722.2	666,982.2
Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,373,017.8	2,048,406.9	675,389.1
Тавилга, аж ахуйн эд хогшил	33,742.3	41,426.6	7,684.3
Зам, гүүрийн байгууламж	102,372.3	102,318.1	(54.3)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	249.9	249.9	-
Бусад үндсэн хөрөнгө	187,096.5	216,901.0	29,804.5
Дуусаагүй барилга, байгууламж	2,704,191.7	3,025,245.3	321,053.7
Ном	241.2	256.0	14.7
Биет бус хөрөнгө	13,877,645.2	13,835,689.6	(41,955.6)
Програм хангамж	17,271.5	19,729.3	2,457.8
Бусад биет бус хөрөнгө	13,860,373.7	13,815,960.2	(44,413.5)
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	6,126,359.7	2,948,483.3	(3,177,876.4)
Биологийн хөрөнгө /ТӨҮГ/	-	577.1	577.1
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө /ТӨҮГ/	139,934.5	172,708.9	32,774.4
Хойшлогдсон татварын хөрөнгө /ТӨҮГ/	128,476.4	108,772.7	(19,703.7)
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө /ТӨҮГ/	1,915.0	1,915.0	-
Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/ + бусад	5,856,033.8	2,664,509.6	(3,191,524.3)
Дүн	27,100,985.5	28,460,193.3	1,359,207.8

Эх сурвалж: ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны 41.0 хувь нь биет хөрөнгө, 48.6 хувь нь биет бус хөрөнгө, 10.4 хувь нь бусад хөрөнгийн үлдэгдэл байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэлд дараах байгууллагуудад материаллаг хэмжээний өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл өмнөх оноос 628,895.3 сая төгрөгөөр буюу 29.6 хувиар өссөн нь нүүрс баяжуулах үйлдвэр, конвейрийн систем, дуусаагүй барилга байгууламжийн хөрөнгө оруулалт, мөн уул уурхайн техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдсэнтэй холбоотой;
- “Эрчис ойл” ХХК өмнөх оноос 50,453.9 сая төгрөгөөр өссөн нь Иргэний нисэхийн ерөнхий газрын Шатахуун хангалтын алба болон Дорноговь аймгийн Замын-Үүд дэх “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” -ын үндсэн хөрөнгүүд нэмэгдэн балансаас баланст шилжүүлэн авсантай холбоотой;
- “Эрдэнэс оюу толгой” ХХК нь өмнөх оноос 7,305.4 сая төгрөгөөр өссөн нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу оффисын зориулалттай 7,497.3 сая төгрөгийн барилга, байгууламж, 8.4 сая төгрөгийн тавилга, эд хогшлыг худалдан авсантай холбоотой;
- “Монголын газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,552,036.3 сая төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-ын 2025 оны 656 дугаар тогтоолын дагуу 42 нэр төрлийн 38,319.5 сая төгрөгийн барилга, байгууламжийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн, мөн тус газрын 2024 оны 205 дугаар тогтоолын дагуу Бүгд Найрамдах Энэтхэг Улсын хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй газрын тос боловсруулах үйлдвэрийн ЕРС-01 багцын 312,075.9 сая төгрөгийн барилга байгууламж, 8.8 сая төгрөгийн өртөгтэй газрыг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэнтэй холбоотой;
- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 564,341.8 сая төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хүрээнд худалдан авсан 294,973.1 сая төгрөг, дуусаагүй барилгын дансанд бүртгэлтэй 410 ширхэг хөрөнгийг ашиглалтад оруулж, үндсэн хөрөнгөд бүртгэсэн 160,129.9 сая төгрөг, их засвар, шинэчлэлийн ажилтай холбоотой 30,582.6 сая төгрөг, хандив тусламжаар хүлээн авсан 34.7 сая төгрөг, өр төлбөрт тооцон хүлээн авсан 460.0 сая төгрөг, Эргэлтийн хөрөнгө болон дараа тайлангийн данснаас машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга, эд хогшлыг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэсэн 1,299.7 сая төгрөг, уул уурхайн зориулалттай 467.4 сая төгрөгийн хөрөнгүүд тус тус нэмэгдсэн;
- “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 1,531,741.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төмөр замын төслийн урьдчилгаа данснаас шилжүүлэн бүртгэсэн барилга байгууламж 2,021,273.2 сая төгрөг, машин тоног төхөөрөмж 383,128.4 сая, тээврийн хэрэгсэлд 15 зүтгүүр, 1 суудлын вагон, 510 ачааны вагон нийт 473,059.6 сая төгрөг, тавилга эд хогшил 40.6 сая төгрөг, компьютер бусад хэрэгсэл 259.3 сая төгрөг, бусад үндсэн хөрөнгө 259.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн;
- “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн үндсэн хөрөнгө 191,553.7 сая төгрөг болж 9,054.6 сая төгрөгөөр өссөн гол шалтгаан нь 27,814.8 сая төгрөгийн хөрөнгө шинээр худалдан авсан, 124.9 сая төгрөгийн тээврийн хэрэгслийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 04 дүгээр сарын 03- ний өдрийн 175 тоот тогтоолоор шилжүүлэн авсан нь нөлөөлсөн;
- “Эрдэнэс монгол” ХХК-ийн үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 4,252.8 сая төгрөгөөр буюу 3.5 хувиар өссөн нь компанийн үйл ажиллагаанд ашиглахаар 21,212.3 сая төгрөгийн 324 нэр төрлийн хөрөнгийг худалдан авсан нь нөлөөлсөн.

Аудитын илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн данстай холбоотой 97,690.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- *Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгө байгаагаас цаашид ашиглах боломжтой эсэхийг тодорхойлж, ашиглах жил, үнийг шинэчлэн тогтоогоогүй, санхүүгийн тайланг бодит үнэ цэнээр тайлагнаагүй /Төр засгийн үйлчилгээг эрхлэх газар 2,476.9 сая төгрөг, Эрдэнэс Оюутолгой ХХК 111.8 сая төгрөг, Шивээ-Овоо ХК 56,429.8 сая төгрөг, Багануур ХК 83,685.6 сая төгрөг, Мон-Атом ХХК 155.6 сая төгрөг, Монголын газрын тос боловсруулах үйлдвэр ХХК 593.3 сая төгрөг, Эрдэнэс Монгол ХХК 2,740.4 сая төгрөг, Эрдэнэс метан ХХК 26.9 сая төгрөг, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ 653.3 сая төгрөг/;*

- Монголын газрын тос боловсруулах үйлдвэр ХХК нь тайлант хугацаанд 126 ширхэг үндсэн хөрөнгийн 156.2 сая төгрөгийн элэгдлийн зардал дутуу тусгасан;
- Эрдэнэс УТП ХХК нь үйлдвэрлэлийн технологийн паркийн судалгаа, шинжилгээ, зөвлөх үйлчилгээ болон техник, эдийн засгийн үндэслэл боловсруулахад зарцуулсан 3 төслийн нийт 181.7 сая төгрөгийн зардлыг биет бус хөрөнгийн бүртгэлд тусгаагүй;
- Эрчист Монгол ТӨХХК-ийн балансад бүртгэлтэй 3 төрлийн 388 ширхэг 358.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг жилийн эцэст тоолсон тооллогын комиссын зарим гишүүд тайлан, дүгнэлтэд гарын үсэг зурж баталгаажуулаагүй;
- Тавантолгой төмөр зам ХХК нь Богдхан төмөр зам төслийн захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн дуусаагүй үйлдвэрлэл дансанд 21,132.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй, туслан гүйцэтгэгч компаниудад өгөх 547.3 сая төгрөгийн өглөгтэй, цаашид төслийн хөрөнгийг бүртгэх, ашиглах эсэхийг эцэслэн шийдвэрлүүлээгүй, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын цогцолбор төслийн 6 багцын 2,822,442.1 сая төгрөгийн хөрөнгийг орлогод авч бүртгэхдээ “Дуусаагүй үйлдвэрлэл” дансанд дээрх хөрөнгөтэй холбоотой 43,659.4 сая төгрөгийн захиалагчийн хяналтын зардлыг үндсэн хөрөнгийн өртөгт шилжүүлэн бүртгээгүй, гүйцэтгэгчээс ирүүлсэн үнийн дүнгээр орлогод авч бүртгэсэн байна;
- Эрдэнэс Монгол ХХК нь өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар “Компанийн өөрийн эзэмшлийн бус газар дээр байрлах, үйл ажиллагаандаа ашигладаггүй 8,715.9 сая төгрөгийн үлдэх өртөгтэй нүүрс экспортлох гаалийн үзлэгийн зориулалттай 33,402 м2 бетон хучилттай үзлэгийн зам талбайг санхүүгийн тайланд тусгаж хөрөнгийн үлдэгдлийг үнэн зөв илэрхийлээгүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй. Ухаа худгаас Гашуун сухайт боомт чиглэлийн хатуу хучилттай замын зориулалтын 21.9 сая м.кв газар эзэмших эрхийг санхүүгийн тайланд биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгээгүй. Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутагт 2.41 га талбайд ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд “Хайгуул ба үнэлгээний үе шат”-ны хээрийн судалгааны ажилтай холбогдуулан 2016-2022 онд гарсан 567.6 сая төгрөгийн зардлыг холбогдох стандартад нийцүүлэн ангилж бүртгээгүйгээр, уул уурхайн хөрөнгө дансанд бүртгэсэн, Говьсүмбэр аймгийн Шивээ-говь сумын нутагт 270 га талбайд ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд ашигт малтмалын нөөцийн үйлдвэрлэлийн зэрэг тогтоох “Хайгуул ба үнэлгээний үе шат”-ны ажилтай холбогдуулан 2016-2022 онд гарсан 214.3 сая төгрөгийн зардлыг холбогдох стандартад нийцүүлэн ангилж бүртгээгүйгээр, уул уурхайн хөрөнгө дансанд бөөн дүнгээр бүртгэсэн, Гашуун Сухайт ХХК-ийн эзэмшлийн 251.0 сая төгрөгийн өртөг бүхий Toyota LC (01-88 УБЕ), 230.0 сая төгрөгийн өртөг бүхий Nissan Patrol (21-93 УББ), 115.0 сая төгрөгийн өртөг бүхий Nissan 461 (70-83 УБЧ) гэсэн гурван суудлын автомашиныг 2018, 2019 оноос эхлэн Эрдэнэс Монгол ХХК-ийн дотоод үйл ажиллагаанд ашиглаж байгаа бөгөөд эдгээр автомашинуудыг шилжүүлэн ашиглуулахтай холбоотой эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, мөн компани хоорондын зохицуулалтгүй;
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь 2014 онд “Номун Гранд” ХХК-тай өр барагдуулах гэрээ байгуулж, нийт 28 айлын 919.9 мкв талбай бүхий 1-2 өрөө орон сууцыг хүлээн авсан ба уг орон сууцтай холбоотой 1,287.9 сая төгрөг, данс бүртгэлд тусгаагүй эзэмших, ашиглах эрхтэй газар, орон сууцтай холбоотой нийт 27,112.6 сая төгрөг, жилийн эцсийн тооллогоор нийт 197.9 сая төгрөгийн хөрөнгө биетээр оршин байхгүй, барилга байгууламжийн данстай холбоотой нийт 10,314.7 сая төгрөг, Бээжин дэх худалдааны төлөөлөгчийн газар, Москва дах худалдааны төлөөлөгчийн газруудыг татан буулгах тухай тушаал гаргасан ч нийт 9,554.7 сая төгрөгийн хөрөнгийг цаашид хэрхэн ашиглах талаар тушаал, шийдвэр гараагүй, хөрөнгийн асуудлыг шийдээгүй;
- Эрдэнэт медиал эмнэлэг тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 136.3 сая төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгөд нийт 12.9 сая төгрөгийн элэгдлийн зардлыг тооцож бүртгээгүй байна.

3.4.8 Өр төлбөр

Өр, төлбөр дансны эцсийн үлдэгдэл 7,230,890.1 сая төгрөг болж, өмнөх оноос 880,887.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Богино хугацаат өр төлбөрийн дүн	5,336,014.1	5,080,144.1	(255,870.0)
Богино хугацаат зээлийн өглөг	431,943.3	157,189.5	(274,753.9)
Өглөг	2,951,287.8	2,377,905.1	(573,382.7)
Урьдчилж орсон орлого	1,952,783.0	2,545,049.5	592,266.5
Урт хугацаат өр төлбөрийн дүн	2,775,763.6	2,150,746.0	(625,017.6)
Урт хугацаат үнэт цаас	849,973.0	849,973.0	-
Урт хугацаат зээл	1,925,790.6	1,300,773.0	(625,017.6)
Нийт өр төлбөрийн дүн	8,111,777.6	7,230,890.1	(880,887.5)

Эх сурвалж: ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр, төлбөр дансны үлдэгдэлд дараах байгууллагуудад материаллаг хэмжээний өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- “Эрчис ойл” ХХК-ийн богино хугацаат зээл дансны үлдэгдэл нийт дүнгээр 14,648.1 сая төгрөгөөр буурсан нь гэрээт худалдан авагч харилцагчид гэрээний дагуу худалдан авах барааны төлбөрөө төлсөнтэй холбоотой;
- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл өмнөх оноос 285,279.9 сая төгрөгөөр буурсан нь Самсунг фирма компаниас авсан 100.0 ам.доллар буюу 68,411.8 сая төгрөгийн зээл, Капитрон банкнаас авсан 8.0 хувийн хүүтэй, 10.0 сая ам.доллар буюу 34,202.5 сая төгрөг, Голомт банкнаас авсан 9.0 хувийн хүүтэй 40.0 сая ам.доллар буюу 136,810.0 сая төгрөгийн зээлийг хаасан, хүүгийн өр төлбөр 559.8 сая төгрөгөөр буурснаас шалтгаалсан;
- “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн өр, төлбөр данс үлдэгдэл өмнөх оноос 47,880.9 сая төгрөгөөр буурсан нь урьдчилж орсон орлого, татварын өглөгийг тус тус бууруулсантай холбоотой.

Аудитын илрүүлэлт:

Өр төлбөрийн данстай холбоотой 3,386,641.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Санхүүгийн тайлан гаргахын өмнө харилцагч байгууллагуудтай өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, /Мон-Атом ХХК 946.4 сая төгрөг, Тавантолгой төмөр зам ХХК 33,052.4 сая төгрөг, Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК 1,231.9 сая төгрөг/;
- Эрдэнэс Оюутолгой ХХК нь өмнөх онд үүссэн 33.8 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн өглөг үүсгэсэн, тайлант хугацаанд 50.0 сая төгрөгөөр тус өр төлбөрийг нэмэгдүүлсэн;
- Удирдлагын академи өмнөх онд болсон үйл ажиллагаа буюу 100 жилийн ойн арга хэмжээний гэрээний үлдэгдэл төлбөрт 36.2 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан;
- Шивээ-Овоо ХК нь Толгой компани болох “Эрдэнэс Монгол” ХХК-аас жилийн 8.4–13.0 хувийн хүүтэй нийт 135,915.4 сая төгрөгийн санхүүжилтийн зээл авсан бөгөөд тайлант хугацааны эцсийн байдлаар 8,195.3 сая төгрөгийн хүүгийн төлбөрийн үлдэгдэлтэй, 6,058.0 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг төлж барагдуулаагүй, НӨАТ сан дансны эхний үлдэгдлийн 1,059.7 сая төгрөгийн дүнг баталгаажуулах хангалттай зохистой нотолгоо байхгүй, тухайн НӨАТ сангийн данс нь яаж үүссэн нь тодорхойгүй;
- Монголын газрын тос боловсруулах үйлдвэр ХХК-д “Эрдэнэс Монгол” ХХК-аас олгосон урт хугацаат зээл болон хүүгийн өглөгийн үлдэгдэл 2025 оны эцэст 1,296,015.3 сая төгрөгт хүрч, компанийн нийт өр төлбөрийн 85.6 хувийг бүрдүүлсэн нь санхүүгийн байдлын үндсэн үзүүлэлтүүдийг доройтуулсан байна. Тайлант хугацаанд зээлийн хүүгийн зардал 27,631.4 сая төгрөгт хүрч, 62,699.3 сая төгрөгийн алдагдалтай ажиллахад голлон нөлөөлжээ. Компани нь хүүгийн зардлыг бууруулах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна;
- Эрдэнэс газ төслийн нэгж нь Эрдэнэс Монгол ХХК-аас олгосон урт хугацаат зээлийн үлдэгдэл 2025 оны эцэст 2,836.9 сая төгрөгт хүрч, компанийн нийт өр төлбөрийн 76.8 хувийг бүрдүүлсэн нь санхүүгийн байдлын үндсэн үзүүлэлтүүдийг доройтуулсан байна. Мөн “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2023.09.18-ны өдрийн 67 дугаар тогтоолоор баталсан “Зээлийн санхүүжилт олгох журам”-ын дагуу толгой компани нь харьяа төслийн нэгжийн удирдлагатай зээлийн санхүүжилтийн гэрээ байгуулаагүй, зээлийн эргэн төлөгдөх хугацаа, хүү тооцох эсэх нь тодорхойгүй байна;
- Эрчист Монгол ТӨХХК Тайлант оны эцэст үндсэн хөрөнгө худалдан авсан 142.9 сая төгрөг, цалингийн өглөг 42.9 сая төгрөг, татварын өр 6.4 сая төгрөг, санхүүгийн тайланд 192.3 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй тайлагнаж, төсвийг зохистой удирдаж ажиллаагүй байна;
- Эрдэнэс тавантолгой ХК Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай 10 дугаар тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн эрх бүхий байгууллага ногдол ашиг хуваарилахаар шийдвэр гаргасан тохиолдолд төрийн өмчид ногдох ногдол ашгийн орлогоос “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Эрдэнэс Монгол” ХХК болон түүний нэгдэлд хамаарах, төрийн өмчийн оролцоотой бусад аж ахуйн нэгжүүдийн хооронд үүссэн өр, авлагыг суутган тооцохоор зохицуулсан. Гэвч энэхүү зохицуулалт бодитоор хэрэгжээгүй бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу 2022–2023 оны төрд ногдох ногдол ашгийн 3,305,196.7 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөр санхүүгийн тайланд бүртгэлтэй байна;
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын өмчлөлийн “Монголиан смелтинг корпорэйшн” ХХК нь үйлдвэрийн арлжааны банкны 407359915 дугаартай дансанд өмнөх эзэмшигчийн данснаас 34,556.25 фунт стерлинг буюу 162.8 сая төгрөгийн буцаалт гэсэн утгатай орлого орж ирсэн бөгөөд компанийн арлжааны банкны валютын дансанд 21,717.5 фунт стерлинг, төгрөгөөрх дансны 133.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-т 153.8 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байгаа ч үйлдвэрт төлөх өглөгийн асуудлыг шийдвэрлээгүй байна. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь 2020 онд Хятадын засгийн газарт зориулж 278.0 сая төгрөг, ОХУ-д 128.2 сая төгрөгийн “Ковид-19”-ийн хандив, 2024 онд Малчдад 142.7 сая төгрөгийн хандив цуглуулах зорилгоор үйлдвэрийн ажилчдын цалингаас 30.0–50.0 мянган төгрөгийг суутган авч Хятадын засгийн газарт 288 сая төгрөг, ОХУ хандив авахаас татгалзсан тул цуглуулсан хандиваас 80.0 сая төгрөгийг Орхон, Булган аймгийн Онцгой байдлын ерөнхий газрууд руу тус тус шилжүүлсэн боловч, нийт суутган авсан хандивыг бүрэн

шилжүүлэлгүйгээр тайлант оны эцэст цалингаас суутгасан бусад өглөг 180.9 сая төгрөгийн өр төлбөртэй байна.

3.4.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 36,148,585.2 сая төгрөг болж, өмнөх оноос 1,872,188.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын хувь оролцоо	20,605,303.6	20,919,790.9	314,487.2
Засгийн газрын оруулсан капитал	39,540.1	39,541.1	1.0
Улсын төсвийн оруулсан хөрөнгө	39,540.1	39,541.1	1.0
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	2,119,967.8	2,119,978.8	11.0
Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	11,196,548.7	11,196,548.7	-
Нэмж төлөгдсөн капитал	757.6	757.6	-
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	7,248,489.5	7,562,964.7	314,475.2
Хуримтлагдсан үр дүн	12,914,870.3	13,965,782.5	1,050,912.3
Өмнөх үеийн үр дүн	4,014,695.4	8,669,901.9	4,655,206.5
Тайлант үеийн үр дүн	8,900,174.9	5,295,880.6	(3,604,294.2)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	755,559.1	1,262,347.8	506,788.7
Хяналтын бус хувь оролцоо	663.9	663.9	-
Дүн	34,276,396.9	36,148,585.2	1,872,188.2

Эх сурвалж: ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 1,872,188.2 сая төгрөгийн өмчийн өөрчлөлт гарсан нь харьяа байгууллагууд 3,604,294.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан, өмчид 14,487.2 сая төгрөгийн өөрчлөлт гарсан, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 506,788.7 сая төгрөг гарсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, ТЕЗ нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн төсөлд санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 171,039.9 сая төгрөг, төсвийн байгууллагын өөрийн орлогоор 175.0 сая төгрөг бүрдүүлж, урсгал зардлыг 88,399.7 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардлыг 82,815.2 сая төгрөг, нийт 171,214.9 сая төгрөг байхаар тооцон төлөвлөж, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

Төсвийн төсөлд өгсөн саналаас улсын төсвөөс санхүүжүүлэх эх үүсвэрийг 29,957.2 сая төгрөгөөр бууруулж, нийт зардлыг 141,257.7 сая төгрөгөөр анх баталсан байна.

Төсвийн тодотголоор санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 96,274.6 сая төгрөг, төсвийн байгууллагын өөрийн орлогоор 300.0 сая төгрөг бүрдүүлэхээр, урсгал зардлыг 73,107.6 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардлыг 23,167.0 сая төгрөг, нийт зарлагыг 96,274.6 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тус ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн гүйцэтгэлээр улсын төсвөөс 81,779.0 сая төгрөг, төсвийн байгууллагын өөрийн орлогоор 338.0 сая төгрөг, нийт 82,117.0 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 300.0 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 338.0 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр урсгал зардалд 60,271.2 сая төгрөгийг, хөрөнгийн зардалд 21,503.9 сая төгрөг, нийт 81,775.1 төгрөгийг зарцуулж, 84.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Хөтөлбөр, арга хэмжээний гүйцэтгэл	96,274.6	81,775.1	14,499.5	84.9
2	70103 Засаглалын ерөнхий удирдлага	79,642.3	67,223.1	12,419.1	84.4
3	70201 Эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт	3,051.0	2,252.4	798.6	73.8
4	70413 Төр, засгийн аж ахуйн үйлчилгээ	9,410.1	8,919.4	490.7	94.8
5	71503 Хот суурингийн ерөнхий төлөвлөлт	4,171.2	3,380.2	791.0	81.0

Эх сурвалж: ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар ЗГХЭГ-ын даргын төсвийн багцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 60,908.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 17 төсөл арга хэмжээний санхүүжилтэд 23,167.0 сая төгрөг батлагдсан. Эрх шилжүүлэх тушаалаар 18,327.4 сая төгрөгийн 15 төсөл арга хэмжээг аймаг, орон нутгийн удирдлага болон харьяа байгууллагад шилжүүлж, 18,393.0 сая төгрөгийг зарцуулсан байна. Тайлант оны төсвийн багцын улсын төсвийн хөрөнгө оруулалтаас эрх шилжээгүй Удирдлагын академийн өргөтгөлийн барилга байгууламжид 1,479.8 сая төгрөг, ЗГХЭГ-ын тоног төхөөрөмж худалдан авалтад 1,631.1 сая төгрөгийг зарцуулж, гүйцэтгэлээр нийт 21,503.9 сая төгрөг зарцуулж, 92.8 хувьтай тайлагнасан байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж, ЗГХХГ нь Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргын харьяа байгууллага болж, шилжин байршсантай холбогдуулан Засгийн газрын II байрны Г корпусын засварын ажил төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

Худалдан авах ажиллагаатай холбоотой 138,102.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Худалдан авалт хийхдээ харьцуулалтын аргаас зайлсхийж, төсөвт өртгийг хэсэгчлэн хувааж шууд худалдан авалт хийсэн тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй; /Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 78.2 сая төгрөг, Монгол Улсын Шадар сайдын ажлын алба (Бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал хариуцсан) 128.5 сая төгрөг, Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа 39.0 сая төгрөг, Эдийн засгийн хөгжлийн төв УТҮГ 52.3 сая төгрөг, Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ 70.3 сая төгрөг, Удирдлагын академи 10.5 сая төгрөг, Шивээ-Овоо ХК 746.6 сая төгрөг, Эрдэнэс ҮТП ХХК 70.5 сая төгрөг, Тавантолгой төмөр зам ХХК 338.5 сая төгрөг, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ 992.7 сая төгрөг, Эрдэнэт медиал эмнэлэг 24.5 сая төгрөг, Чингисхаан ҮБС ХХК 54.7 сая төгрөг/;
- “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тухайн жилийн төлөвлөгөөнд тусгаагүй, үр дүнг дүгнээгүй, хэрэгжилт хангалтгүй /Шивээ-Овоо ХК 640.6 сая төгрөг, Эрдэнэс тавантолгой ХК 27,500.0 сая төгрөг/;
- Шивээ-Овоо ХК нь Баруун Баянгийн Ширээ ХХК-тай байгуулсан ШО25-4/119 дугаар гэрээгээр 1 м³ уулын цул тээвэрлэлтийн хөлсийг 3,216 төгрөгөөр тооцохоор заасан боловч гүйцэтгэлийн актад 3,279 төгрөгөөр тооцож, 13.0 сая төгрөгийн илүү төлбөр олгосон нь гэрээний үнийг зөрчсөн байна.
- Гэрээний хэрэгжилт хангаагүй, хугацаанд нь ашиглалт оруулаагүй, барааг хүлээн аваагүй, хугацаа хэтэрсэнд алданги суутгаагүй /Багануур ХК 11,600.0 сая төгрөг, Эрдэнэт үйлдвэр 68,946.4 сая төгрөг, Эрдэнэс критикал минералс ТӨҮГ 8,413.6 сая төгрөг/;
- Эрчист Монгол ТӨХХК-д картлагдаагүй 87 ширхэг 25.2 сая төгрөгийн тавилга эд хогшил, 34 ширхэг 53.0 сая төгрөгийн компьютер, түүний дагалдах хэрэгслийг ашиглалтад тавьж олгоогүй, хэрэгцээ шаардлагад үндэслэн худалдан авалтыг зохион байгуулж ажиллаагүй байна;
- Эрдэнэс тавантолгой ХК нь бэлтгэн нийлүүлэгчидтэй байгуулсан зарим гэрээний хэрэгжилт, ажлын гүйцэтгэлд тавих хяналт сул байгаагаас гэрээний хугацаа хэтрэх, нийлүүлэх бараа материалыг хүлээн аваагүй, ажил үйлчилгээний гүйцэтгэлийг дүгнэж гэрээг хаагаагүй 5,805.8 сая төгрөг;
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь уурхайн хүнд даацын өөрөө буулгагч автомашин Komatsu HD1500-8 маркийн тээврийн хэрэгслийг худалдан авсан ч нийлүүлж зарлаагүй тендерийн үр дүнд нэгж тээврийн хэрэгслээс 584.5 сая төгрөг, нийт 2,338.0 сая төгрөгийн алдагдалтай гэрээ байгуулсан, 36,122.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Өвлийн дизель түлш I"-ийг Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авахаар төлөвлөсөн ч тус тендер шалгаруулалттай холбоотой нийт 9,886.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн;

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

- *Эрдэнэс критикал минералс ТӨҮГ нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 5,774.2 сая төгрөгийн 24 арга хэмжээг нэмж, 16,701.3 сая төгрөгийн 51 арга хэмжээг хасаж, 10,926.6 сая төгрөгөөр бууруулан 3 удаа өөрчлөлт оруулсан, өмнөх оноос дамжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээг төлөвлөгөөнд тусгахгүй орхигдуулдаг, төсөвт өртгийн хэмжээг зөрүүтэй тусгаадаг, төлөвлөлтийг үндэслэлтэй төлөвлөөгүй байна;*
- *Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК нь Tender.gov.mn цахим системд тендер сонгон шалгаруулалтын гэрээний үр дүнг бүрэн байршуулаагүй байна;*
- *Мэдээ мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг сонгон шалгаруулалт зохион байгуулж ил тод зохион байгуулж сонгоогүй, шууд гэрээ байгуулсан /Засгийн газрын хэрэг эрхлэх газар 118.6 сая төгрөг, Эрдэнэс Оюутолгой ХХК 255.0 сая төгрөг, Эрдэнэс ашид ХХК 39.8 сая төгрөг, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ 362.7 сая төгрөг/.*

3.5.4 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн хавсралтаар баталсан тус ТЕЗ-ын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд 2 арга хэмжээний зорилтот түвшнийг тусгажээ.

Хүснэгт 11. ТЕЗ-ын 2025 оны хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт

		<i>/мянган төгрөгөөр/</i>					
Хөтөлбөр	Шалгуур үзүүлэлт	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Суурь түвшин	2025 оны зорилтот түвшин	2025 онд хүрсэн түвшин	
21.1	Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн мэдээлэл, хөтөлбөр, төслийн мэдээлэл болон үйл ажиллагааны үр дүнгийн мэдээлэл, танилцуулгыг төлөвлөсөн хугацаанд хийсэн байна	Хууль болон журамд заасан хугацаанд тайлагнасан эсэх	35,663,047.9	31,990,935.4	100	100	100
21.2	Төр, засгийн төв байгууллага болон хэрэглэгчийн хэвийн үйл ажиллагаанд олон улсын чанарын менежментийн MNS-ISO 9001:2016 стандартыг хангаж ажиллана.	MNS-ISO 9001:2016 стандартын шаардлагыг хангах	9,110,113.1	8,592,403.0	100	100	100

Эх сурвалж: ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.5 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор санхүүжилтийг ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгийн зардалд 11,211.1 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,708.9 сая төгрөг, нийт 13,920.0 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, 13,913.2 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулж, 6,847.3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудлын орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн үйл ажиллагааг сайжруулах, хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн хөрөнгийн бүртгэл, дотоод хяналтыг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын Б.Лхагвацэнд, аудитор С.Билгүтэй нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер И.Эрдэнэцэцэг, газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2026 оны 04 дүгээр сарын 03-ний өдрийн ХЭГ/1084 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 111,937.3 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 1,131.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэн гүйцэтгэлийн үе шатанд 2025 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 5,261,464.8 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 52,614.7 сая төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлж, төрийн болон орон нутгийн өмчлөлд бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгслийн улсын дугаарыг бусад тээврийн хэрэгслээс ялгагдах тод өнгө бүхий улсын дугаараар сольж, бүтэц орон тоог цөөлөх, хурал, томилолтын зардлыг цахим болгож, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Харьяа байгууллагуудад илэрсэн нийцлийн зөрчил

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийцлийн аудиттай холбоотой нийт 4,192,231.8 сая төгрөгийн 96 зөрчил илэрсэнд 3,959,683.4 сая төгрөгийн 38 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 232,232.0 сая төгрөгийн 57 зөрчилд зөвлөмж өгч, 316.4 сая төгрөгийн 1 зөрчилд хариуцлага тооцуулах албан шаардлага

хүргүүлсэн байна..

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 19 байгууллага шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүйгээс нийт 94,923.0 сая төгрөгийн зөрчил илэрч, 5 албан шаардлага, 14 зөвлөмж өгсөн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар бусад хууль тогтоомжийн хүрээнд нийт 4,097,308.8 сая төгрөгийн 77 зөрчил илэрсэнд 33 зөрчилд албан шаардлага, 1 зөрчилд хариуцлага тооцуулах албан шаардлага өгч, 43 зөрчилд зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээлэл болон бусад нийцлийн асуудал нь Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох хуулийн зарим зүйл заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Харьяа байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах томоохон аж ахуйн нэгжүүд нь хөрөнгө оруулалтын удирдлагын бодлого, зарчмыг бүрэн хэрэгжүүлээгүй, охин, хараат болон бусад төрийн өмчит компаниудад хийж буй хөрөнгө оруулалтын үр ашиг, эргэн төлөлтийн хугацаа, өгөөжийн түвшинг урьдчилан тооцсон эдийн засгийн үндэслэл, судалгаа хангалтгүй байна. Тухайлбал: “Эрдэнэс Монгол” ХХК нь нэгдлийн хараат болон охин 11 компанид эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн санхүүжилт олгож, 163,631.3 сая төгрөгийн үндсэн зээлийн авлага болон холбогдох хүүгийн авлагыг санхүүгийн тайланд бүртгэн тусгасан байна. Мөн “Эрдэнэс Тавантолгой” ХК нь 5 аж ахуйн нэгжид ижил нөхцөлтэй зээлийн санхүүжилт олгож, нийт зээл болон хүүгийн 918,021.9 сая төгрөгийн авлагыг тайлагнасан байна.

Дээрх зээлийн санхүүжилтүүд нь нэгдлийн түвшинд хөрөнгө оруулалтын үр ашиг, өгөөжийн шалгуур үзүүлэлттэй уялдаагүй, эрсдэлийн удирдлагын бодлого дутмаг хэрэгжсэнээс найдваргүй авлагын эрсдэлийг нэмэгдүүлэх, зээлийн эргэн төлөлтийн тодорхой бус байдлыг бий болгох нөхцлийг бүрдүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 14 дүгээр зүйлийн 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т "төрийн өмчит хуулийн этгээдийн өөрт олгогдсон эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах хэмжээ, хязгаарыг энэ хуульд нийцүүлэн тогтоох", 12 дугаар зүйлийн 12.1-т "Эрхэлсэн салбар, хүрээний төрийн өмчит хуулийн этгээдийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, захиалга, төлөвлөлт, хөрөнгө оруулалт, шаардлагатай бусад асуудлаар санал боловсруулж холбогдох газарт оруулна" гэсэнтэй тус тус нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Нэгдлийн түвшинд хөрөнгө оруулалт болон санхүүжилтийн нэгдсэн бодлого, журмыг мөрдүүлэх, зээлийн гэрээний стандарт нөхцөл, зээлийн ангилал, зэрэглэлийг нарийвчлан тогтоох, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад хяналт тавьж ажиллах зөвлөмж өглөө.

2. Харьяа байгууллагуудын дотоод хяналттай холбоотой

ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийцлийн аудиттай холбоотой нийт 4,192,231.8 сая төгрөгийн 96 зөрчил илэрсэнд 3,959,683.4 сая төгрөгийн 38 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 232,232.0 сая төгрөгийн 57 зөрчилд зөвлөмж өгч, 316.4 сая төгрөгийн 1 зөрчилд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэнтэй нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Нийцлийн зөрчил их хэмжээгээр илэрч байгаа тул дотоод хяналтыг эрчимжүүлж, зөрчил давтагдахаас сэргийлэх, бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх зөвлөмж өглөө.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Засгийн газрын хэрэг эрхлэх газрын орон тооны бүтцээс тайлант оны эхний хагас жилээс хасагдаж, бусад ерөнхийлөн захирагчийн бүрэлдэхүүнд хамаарах Хяналт, үнэлгээний үндэсний хорооны ажлын алба, 20 минутын хот үндэсний хорооны ажлын алба, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны ажлын алба, Эрчим хүчний реформыг удирдан зохион байгуулах үндэсний хорооны ажлын албадын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 4,221.0 сая төгрөгийн 16 зөрчил илэрсэн байна.

4.5.2. Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний дүн

Өмнөх оны аудитаар 4 зөрчил илэрсэнд зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 3 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 13. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Д/д	Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Албан шаардлага	1	-	1	-	100.0
2	Зөвлөмж	3	-	3	-	100.0
	Нийт дүн	4	-	4	-	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын хэрэгжүүлж буй Төрийн ёслол Хүндэтгэлийн их танхимын засвар шинэчлэлтийн дуусаагүй ажлыг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 85,674.8 сая төгрөгийн 27 алдаа¹ илэрсэнд 70,799.9 сая төгрөгийн 26 алдааг аудитын явцад бүрэн залруулж, 14,874.8 сая төгрөгийн 1 залруулаагүй алдаанд зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар 5,883,169.9 сая төгрөгийн 234 зөрчил²

¹Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

илэрсэнд, 165.9 сая төгрөгийн 17 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3,862,977.9 сая төгрөгийн 109 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 10,236.7 сая төгрөгийн 6 зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, 4,811.8 сая төгрөгийн 1 зөрчлийг хууль, хяналтын байгууллагад шилжүүлж, 2,004,977.5 сая төгрөгийн 101 зөрчилд зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 5,883,169.9 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул “Хязгаарлалтай” дүгнэлт өглөө.

5.1 Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа зөрчил

ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 44 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 19 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 25 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан бөгөөд 4 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, 14 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, 1 байгууллагын санхүүгийн тайланд “Сөрөг” дүгнэлт өгсөн байна.

5.2 Төсвийн ерөнхийлөн захирагч

Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар 3 зөрчил илэрсэнд 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн.

5.2.1 Албан шаардлага

1. “Тавантолгой төмөр зам” ХХК нь 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар “Сөрөг” санал дүгнэлт авсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 12 дугаар зүйлийн 12.4, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 67 дугаар зүйлийн 67.1, 67.2, 72 дугаар зүйлийн 72.5, 73 дугаар зүйлийн 73.4 дэх заалтуудтай нийцээгүй, НББОУС 1.15, 16.11, СТОУС 13.24-ыг мөрдөөгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой, орших байх, эрх ба үүрэг, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлүүдийг хангаагүй, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэнтэй тус тус нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42.1-д заасан дагуу буруутай албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.

5.2.2 Зөвлөмж:

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт:

1. ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй 161,512.3 сая төгрөг, төсвийн хөрөнгийг үр ашиггүй, аривлан хэмнэлтгүй зарцуулсан 15,729.3 сая төгрөг, дотоод хяналт сул, нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 2,032,387.3 сая төгрөг, худалдан авах ажиллагаатай холбоотой 12,665.0 сая төгрөг зэрэг санхүүгийн тайлангийн аудитаар нийт 5,968,844.7 сая төгрөгийн 260 алдаа, зөрчил илэрсэнд 85,674.8 сая төгрөгийн 27 алдааг залруулж, 223.8 сая төгрөгийн 18 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3,862,920.1 сая төгрөгийн 108 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2,004,977.5 сая төгрөгийн 100 зөрчилд зөвлөмж өгч, 10,236.7 сая төгрөгийн 6 зөрчилд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж, 4,811.8 сая төгрөгийн 1 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой

удирдлагыг хэрэгжүүлэх", 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын тогтолцоо, үйл ажиллагааг сайжруулах, эрсдэлд суурилсан дотоод хяналт шалгалт гүйцэтгэж, илэрсэн зөрчлийг бууруулж ажиллах зөвлөмж өглөө.

Илрүүлэлт:

2. ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн шийдвэрлэх боломжгүй доорх асуудлуудыг дээд шатны төсөв захирагчид хүргүүлэхээр шийдвэрлэсэн байна. Үүнд:

- “Шивээ-Овоо” ХК нь “Эрдэнэс Монгол” ХХК-тай байгуулсан менежментийн гэрээний дагуу 2016 оноос эхлэн 11,213.5 сая төгрөгийн менежментийн төлбөрийн өр төлбөр хуримтлагдан бүртгэгдсэн. Уг менежментийн төлбөрийг борлуулалтын орлогын 2 хувиар тооцохоор гэрээнд заасан бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, тогтоолоор дамжуулан зургаан төрлийн үйлчилгээ үзүүлэхээр тусгасан байна. Эдгээр үйлчилгээний өртөг болон менежментийн төлбөрийн хэмжээ нь компанийн санхүүгийн чадавх, ашигт ажиллагаатай уялдахгүй байгаа асуудал;
- “Зэс боловсруулах цогцолбор” ХХК нь “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ-ээс санхүүжилт авдаг боловч санхүүжилтийн гэрээ байгуулаагүй, батлагдсан төсвийн дагуу орж ирсэн санхүүжилтийг орлогоор бүртгэж, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлж, нягтлан бодох бүртгэл, тайлагналыг стандартын дагуу хөтлөөгүй;
- “Эрчист Монгол” ТӨХХК нь 2025 оны санхүүгийн тайланд 1,483.8 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй тайлагнасан бөгөөд харьяа компаниудын мөнгөн урсгалын дутагдлаас шалтгаалан менежментийн орлогыг бүрэн төвлөрүүлэхэд хүндрэлтэй, цаашид өр төлбөрийг барагдуулах талаар тодорхой шийдэлгүй байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 34² дугаар зүйлийн Сайдын ажлын алба 1-т "Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэнтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд дээрх байгууллагын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх төлөвлөгөө боловсруулан баталж, санхүү, бүртгэл тайлагналд хяналт хийж, холбогдох саналыг Санхүү төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны дээд байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэх зөвлөмж өглөө.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01 - ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6 АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Алдаа										
		Алдааны дүн		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсантай холбоотой		Буруу тусган илэрхийлсэнтэй холбоотой		Залруулсан		Залруулаагүй		
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	Зөвлөмж
I.ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУД												
1	Эрдэнэс Монгол ХХК	1	336.5			1	336.5	1	336.5			
2	Багануур ХК	6	79,301.4			6	79,301.4	5	64,426.5	1	14,874.8	1
3	Эрдэнэс Алт ресурс ХХК	1	83.9			1	83.9	1	83.9			
4	Тавантолгой төмөр зам ХХК	5	2,695.2			5	2,695.2	5	2,695.2			
5	Мон-Атом ХХК	6	1,969.7			6	1,969.7	6	1,969.7			
6	Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар	5	1,178.1	1	-	4	1,178.1	5	1,178.1			
7	Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа	3	109.9	1	5.0	2	104.9	3	109.9			
Нийт дүн		27	85,674.8	2	5.0	25	85,669.8	26	70,799.9	1	14,874.8	1

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Санхүүгийн тайлангийн аудитын зөрчил												
		Нийт дүн		Акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			Үүнээс хууль, хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн асуудал	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	Албан тушаалтны тоо	тоо	дүн
I.ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ														
1	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	3	-					2	-	1	-	1		
II.ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУД														
2	Монгол Улсын Ерөнхий сайдын ажлын алба	1	11.0					1	11.0					
3	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	2	166.2			1	88.0	1	78.2					
4	Монгол Улсын шадар сайд /БХОБАХ/	3	150.5			2	141.2	1	9.2					
5	Монгол Улсын шадар сайд /ГХХОАХ/	1	14.1					1	14.1					
6	Эдийн засгийн хөгжлийн төв УТҮГ	2	104.1					2	104.1					
7	Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар	9	2,890.3			3	208.0	6	2,682.4					
8	Удирдлагын академи	4	49.3			2	13.1	2	36.2					
9	Засгийн газрын авто бааз	6	178.1	1	9.7	3	121.1	2	47.3					
10	Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар	3	40.4	1	2.9	1	36.6	1	0.9					
11	Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа	9	246.9			5	199.9	4	47.0					
12	Эрдэнэс Монгол ХХК	27	43,986.4	2	69.9	13	40,993.8	11	2,922.7	1	-	1		
13	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	55	262,898.8	1	18.2	36	221,030.0	14	27,683.8	3	9,354.9	3	1	4,811.8

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

14	Эрдэнэс критикал минералс ТӨҮГ	6	13,367.0			3	11,208.3	3	2,158.7					
15	Эрдэнэс тавантолгой ХК	7	5,278,189.6			3	3,338,502.6	4	1,939,687.0					
16	Багануур ХК	9	12,912.7	1	27.7	4	1,280.0	4	11,605.0					
17	Шивээ овоо ХК	13	22,239.1	2	14.1	6	12,028.0	4	9,315.2	1	881.8	1		
18	Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК	6	1,490.7					6	1,490.7					
19	Эрдэнэс Алт ресурс ХХК	4	42,385.8	2	9.2	2	42,376.6							
20	Эрдэнэс Оюутолгой ХК	8	555.3			4	434.5	4	120.8					
21	Монголын газрын тос боловсруулах үйлдвэр ХХК	5	31,203.6			3	30,454.0	2	749.5					
22	Тавантолгой төмөр зам ХХК	13	161,594.1	1	8.6	9	161,366.6	3	218.9					
23	Эрдэнэт медиал эмнэлэг	12	719.8	3	2.2	2	210.4	7	507.1					
24	Мон-Атом ХХК	5	988.1	2	1.7	2	946.4	1	40.0					
25	Чингисхаан ҮБС ХХК	3	56.6	1	1.7			2	54.9					
26	Эрдэнэс ашид ХХК	2	47.4					2	47.4					
27	Эрдэнэс метан ХХК	2	30.3					2	30.3					
28	Эрдэнэс ҮТП ХХК	6	2,004.1			2	1,020.8	3	983.2	1	-	1		
29	Зэс боловсруулах цогцолбор ХХК	2	2.3					2	2.3					
30	Эрдэнэс газ төслийн нэгж	1	2,837.0					1	2,837.0					
31	Эрчист Монгол ТӨХХК	8	1,810.3			3	317.9	5	1,492.4					
Дүн		234	5,883,169.9	17	165.9	109	3,862,977.9	101	2,004,977.5	6	10,236.7	6	1	4,811.8
Нийт дүн		237	5,883,169.9	17	165.9	109	3,862,977.9	103	2,004,977.5	7	10,236.7	7	1	4,811.8

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийцлийн аудитын зөрчил									Үүнээс ШД хэрэгжилт	
		Нийт дүн		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага				
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	ХТ Албан тушаалтны тоо	тоо	дүн
I.ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ												
1	Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	2	-			2	-					
	Дүн	2				2						
II.ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУД												
2	Монгол Улсын Ерөнхий сайдын ажлын алба	1	-			1	-					
3	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	1	-			1	-				1	-
4	Монгол Улсын шадар сайд /БХОБАХ/	1	151.4			1	151.4				1	151.4
5	Монгол Улсын шадар сайд /ГХОХАХ/	1	-			1	-				1	-
6	Эдийн засгийн хөгжлийн төв УТҮГ	1	-			1	-				1	-
7	Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар	2	376.8			1	60.4	1	316.4	1		
8	Удирдлагын академи ТӨҮГ	3	399.2	1	24.2	2	375.0				1	216.6
9	Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ	2	2,227.0	2	2,227.0							
10	Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ	4	790.0	2	93.4	2	696.6				1	180.0
11	Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа	3	574.1	1	574.1	2	-				1	574.1
12	Эрдэнэс Монгол ХХК	12	2,635.8	8	2,635.8	4	-				1	918.8
13	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	7	547,902.3	4	430,632.6	3	117,269.8				1	-
14	Эрдэнэс критикал	1	451.2	1	451.2	0	-					

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	минералс ТӨҮГ											
15	Эрдэнэс тавантолгой ХК	15	3,475,010.3	6	3,475,010.3	9	-					
16	Багануур ХК	1	20,303.1	1	20,303.1	0	-					
17	Шивээ овоо ХК	2	38,583.0	1	27,369.5	1	11,213.5			1	27,369.5	
18	Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК	1	-		-	1	-			1	-	
19	Эрдэнэс Алт ресурс ХХК	4	21,568.8	1	19.8	3	21,549.0			1	-	
20	Тавантолгой төмөр зам ХХК	7	295.7	3	178.4	4	117.3			1	117.3	
21	Эрдэнэт медиал эмнэлэг	1	-	1	-					1	-	
22	Мон-Атом ХХК	2	140.2	2	140.2					1	101.2	
23	Чингисхаан ҮБС ХХК	5	57.8	1	23.9	4	33.9			1	-	
24	Эрдэнэс ашид ХХК	2	-	1	-	1	-					
25	Эрдэнэс метан ХХК	6	5,391.1	2	-	4	5,391.1					
26	Эрдэнэс ҮТП ХХК	6	75,374.1			6	75,374.1			1	65,294.1	
27	Зэс боловсруулах цогцолбор ХХК	2	-			2	-			1	-	
28	Эрчист Монгол ТӨХХК	3	-			3	-			1	-	
Дүн		96	4,192,231.8	38	3,959,683.4	57	232,232.0	1	316.4	1	19	94,923.0
Нийт дүн		98	4,192,231.8	38	3,959,683.4	59	232,232.0	1	316.4	1	19	94,923.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1428/А0111371

Улаанбаатар хот

САГ-2026/8/НА-СТА-ТЭЗ

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн төсвийн захирагч нь 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар “Сөрөг” дүгнэлт авсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.6.1-д “төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх” гэж заасантай нийцэхгүй байна.


Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэж заасан үндэслэл бүрдсэн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.2-т “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд “Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага” хүргүүлнэ” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар “Сөрөг” дүгнэлт авсан гүйцэтгэх захирал /Х.Пүрэвжаргал/-д хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга /Б.Энхбаяр/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



С.МАГНАЙСҮРЭН